



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/203

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтыг хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Булган Мээж" ОНӨХХК харьяа төв халуун усны барилгын засварын зураг төсөл боловсруулах ажлыг 19,000,000 (арван есөн сая) төгрөгөөр "Вилла проект" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Вилла проект" ХХК-ийн захирал (Ч.Сод-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д тус тус даалгасугай.

4. Дээрх ажлуудын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010994